


**Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн 2019 оны жилийн эцсийн  
статистикийн тайлан  
/2019.01.01-11.30 хүртэлх/**

**АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

Амбулаторийн үзлэг 308,504 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 22,625 буюу 8,3%-аар өссөн байна.




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад :  
Урьдчилан сэргийлэх үзлэг – 454 буюу 3%-аар буурсан.  
Амбулаторит анхан үзлэг – 8274 буюу 4%-аар, давтан үзлэг 14805 буюу 17%-аар өссөн байна.

**ОСОЛ ГЭМТЭЛ**

2019 онд осол гэмтлийн шалтгаант 321 өвчлөл бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 215 буюу 67%-аар нэмэгдсэн байна.

Осол гэмтлийн өвчлөлийг төрлөөр харуулбал:




- ✓ Хүнд зодуулсан - 148
- ✓ Амьгүй механик хүчинд өртөх – 80
- ✓ Бүх төрлийн уналт – 43
- ✓ Мал амьтанд мөргүүлэх, хөшиглүүлэх-28
- ✓ Зам тээврийн осол – 22

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл нь өмнөх онтой харьцуулахад 67%-аар өссөн байгаа нь эмч, мэргэжилтэнгүүдийг ГССҮТ-өөс зохион байгуулсан осол гэмтлийг яаж бүртгэж мэдээлэх, оношийг хэрхэн тавих зэрэг сургалтуудад хамруулсан тул бүртгэл мэдээлэл сайжирсан нь харагдаж байна.

## СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2019 онд стационарт 23,415 хэвтэн эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж урьд оны мөн үеийнхээс 1,347 тохиолдлоор буюу 5,7%-аар өссөн байна.


Стацинорит хэвтэн эмчлүүлсэн хүн болон ор хоног:



Нийт ашигласан ор хоног 156,859 бөгөөд дундаж ор хоног 6,6 орны эргэлт 45,9 байна

## МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ онд нийт 11,861 мэс засал орж өмнөх оноос 819 буюу 6,9%-аар өссөн байна.




Төлөвлөгөөт мэс засал 404 буюу 4,5%, яаралтай мэс засал 415 буюу, 13,9%, дурангийн мэс засал 1365 буюу 35,4%-аар тус тус өссөн байна.

## НАС БАРАЛТ


Энэ онд нас баралтын 378 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 60 тохиолдол нь буюу 15,8%-ийг эмнэлэгт хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Урьд онтой харьцуулвал нас баралт 1 тохиолдол, хоног болоогүй нас баралт 6 тохиолдлоор тус тус буурсан байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт 9 тохиолдол 1,3% эзэлж байгаа бөгөөд 7 тохиолдол нь архины шалтгаант нас баралт байна.



Нас баралтын бүтцийг авч үзвэл:



Нас баралтын өвчлөлийн бүтцээр авч үзвэл ХБЭ 99 буюу 26,1% хавдар 64 буюу 16,9%, цус харвалт 55 буюу 14,5%, АЗЭ 52 буюу 13,7% БШЗЭ 30 буюу 7,9%-ийг тус тус эзэлж байна.